



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/219

Булган сум

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Хөрсний доройтол, орчны бохирдол бууруулах зорилгоор дулаан, цэвэр усны төв шугамын шинэчлэлт (Рашаант сум)”-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Си Эм Эс” ХХК-тай 799,879,056 (долоон зуун ерэн есөн сая найман зуун далан есөн мянга тавин зургаа) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Си Эм Эс” ХХК-ийн захирал (Т.Батхүрэл)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
 04 дүгээр сарын 30-ны ний өдрийн
 А/319 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	13,889,200	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Захиалагчийн техник хяналтын зардал	13,889,200	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	6,944,600	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
4	Нормчлолын сан	1,250,028	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
7	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
8	Ажил гүйцэтгэх хугацаа	2026.05.01-2026.09.31 2027.05.01-2027.08.31	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
А/319 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	С.Энхбадрал	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Дулааны инженер	А.Сосорбурам	
3	Усан хангамж, ариутгах татуургын инженер	Ч.Буянтогтох	
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	Р.Эрхэмбаяр	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Автокран	7617 УКМ	
2	Ачааны автомашин	3608 УНР 3608 МЧ	
3	Эксковатор	1034 ММВ	

--o00o--